



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/193/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 99900662 Цахим хаяг: [baterdenee@audit.gov.mn](mailto:baterdenee@audit.gov.mn)

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: [erdenechimegg@audit.gov.mn](mailto:erdenechimegg@audit.gov.mn)

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан .....	9
3.1 Ерөнхий зүйл .....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал .....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	13
4. Аудитын илрүүлэлт .....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	13

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

67120. Хөвсгөл аймаг. Мөрөн сум  
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93  
Э-майл: khuvsgul@audit.gov.mn  
Вэбсайт: www.audit.mn

2022.02.09 № 01/62  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ НУУР, ЭГИЙН ГОЛЫН САВ  
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ И.НАЙМАНЖИН ТАНАА

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл нуур, Эгийн голын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл нуур, Эгийн голын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>46,388,516.01</b>	<b>47,212,811.26</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	13,291,116.01	599,611.26
33300	Татаас, санхүүжилтийн авлага	13,120,000.00	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	171,116.01	599,611.26
3351	Байгууллагаас авах авлага	171,116.01	599,611.26
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	33,097,400.00	46,613,200.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	20,398,100.00	27,936,100.00
35110	Тусгай зориулалттай материал	20,398,100.00	27,936,100.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	12,699,300.00	18,677,100.00
35410	Бичиг хэргийн материал	490,400.00	626,100.00
35420	Аж ахуйн материал	748,000.00	771,400.00
35450	Барилгын засварын материал	6,668,000.00	9,827,700.00
35470	Бусад хангамжийн материал	4,792,900.00	7,451,900.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,059,426,055.60</b>	<b>3,934,023,189.60</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	4,059,426,055.60	3,934,023,189.60
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,079,253,555.60	2,952,381,939.60
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,358,087,891.19	2,358,087,891.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	-157,778,777.28	-237,031,861.32
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,600,000.00	33,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-3,266,666.69	-8,866,666.73
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	89,112,204.79	73,575,220.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	-86,695,665.11	-3,070,526.90
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,782,369.74	7,560,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,223,102.64	-885,282.90
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,161,772,812.00	1,161,772,812.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-316,137,510.40	-432,360,146.56
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	980,172,500.00	981,641,250.00
39301	Програм хангамж	550,000.00	2,050,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-581,250.00
39303	Бусад биет бус хөрөнгө	980,172,500.00	980,172,500.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,105,814,571.61</b>	<b>3,981,236,000.86</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,105,814,571.61</b>	<b>3,981,236,000.86</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,105,814,571.61	3,981,236,000.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,149,478,579.00	2,149,478,579.00
51101	Өмч: - төрийн	2,149,478,579.00	2,149,478,579.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	705,841,261.54	582,252,026.13
51210	Өмнөх үеийн үр дүн	705,841,261.54	706,830,596.88
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-124,578,570.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,250,494,731.07	1,249,505,395.73
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,105,814,571.61</b>	<b>3,981,236,000.86</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>865,467,100.00</b>	<b>598,488,920.82</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>228,772,000.00</b>	<b>65,161,320.82</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	228,772,000.00	65,161,320.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	228,772,000.00	65,161,320.82
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,536,000.00	295,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	227,236,000.00	64,865,520.82
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>636,695,100.00</b>	<b>210,418,500.00</b>

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	322,909,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>139,010,000.00</b>	<b>46,944,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	139,010,000.00	46,944,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>497,685,100.00</b>	<b>163,474,500.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	497,685,100.00	163,474,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>818,965,102.94</b>	<b>723,067,491.57</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>818,965,102.94</b>	<b>723,067,491.57</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>762,627,502.64</b>	<b>700,447,142.30</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>235,999,998.42</b>	<b>235,987,304.58</b>
210101	Үндсэн цалин	235,999,998.42	235,987,304.58
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>29,143,774.60</b>	<b>30,550,924.79</b>
210201	Тэтгэврийн даатгал	19,816,500.92	21,409,550.79
210202	Тэтгэмжийн даатгал	1,963,269.59	2,359,873.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,404,242.09	1,887,897.00
210204	Ажилгүйдлийн даатгал	455,173.13	436,775.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,504,588.87	4,456,829.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>143,055,733.17</b>	<b>140,345,527.11</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,405,853.17	3,401,960.37
210302	Түлш, халаалт	135,800,606.00	134,400,388.74
210303	Цэвэр, бохир ус	3,849,274.00	2,543,178.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>22,598,195.50</b>	<b>18,225,799.00</b>
210401	Бичиг хэрэг	1,476,100.00	858,400.00
210402	Тээвэр, шатахуун	10,785,000.00	8,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,459,775.50	803,594.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	74,000.00	70,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,512,652.00	2,511,805.00
210408	Бараа материал акталсны зардал	5,290,668.00	5,481,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,287,100.00</b>	<b>12,802,700.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	240,000.00
210604	Урсгал засвар	9,287,100.00	12,562,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>588,000.00</b>	<b>768,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	588,000.00	768,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,200,000.00</b>	<b>3,670,500.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,200,000.00	481,000.00
210807	Газрын төлбөр	00.00	3,189,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>319,754,700.95</b>	<b>258,096,386.82</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	127,923,000.00	53,448,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	191,831,700.95	204,648,386.82
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>56,337,600.30</b>	<b>22,620,349.27</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>50,673,600.00</b>	<b>16,439,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	50,673,600.00	15,939,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	500,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>5,664,000.30</b>	<b>6,181,349.27</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>46,501,997.06</b>	<b>-124,578,570.75</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>46,501,997.06</b>	<b>-124,578,570.75</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,149,478,579.00	1,250,494,731.07	705,841,261.54	4,105,814,571.61
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	989,335.34	989,335.34
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,149,478,579.00	1,250,494,731.07	706,830,596.88	4,106,803,906.95
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-989,335.34	00.00	-989,335.34
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-124,578,570.75	-124,578,570.75
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,149,478,579.00	1,249,505,395.73	582,252,026.13	3,981,236,000.86

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>638,231,100.00</b>	<b>546,743,400.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,536,000.00</b>	<b>295,800.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,536,000.00	295,800.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	1,536,000.00	295,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,536,000.00	295,800.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>636,695,100.00</b>	<b>546,447,600.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	322,909,100.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	139,010,000.00	60,064,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	139,010,000.00	60,064,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>497,685,100.00</b>	<b>163,474,500.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	497,685,100.00	163,474,500.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>638,231,100.00</b>	<b>532,363,400.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>638,231,100.00</b>	<b>532,363,400.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>568,773,499.70</b>	<b>509,743,050.73</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>235,999,998.32</b>	<b>235,988,351.04</b>
210101	Үндсэн цалин	235,999,998.32	235,988,351.04
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>29,314,890.71</b>	<b>30,378,762.32</b>
210201	Тэтгэврийн даатгал	19,899,841.32	21,318,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,051,045.30	2,327,562.32

210203	ҮОМШӨ-ний даатгал	2,404,242.09	1,795,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	455,173.13	448,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,504,588.87	4,488,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>143,055,733.17</b>	<b>140,945,138.37</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,405,853.17	3,401,960.37
210302	Түлш, халаалт	135,800,606.00	135,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,849,274.00	2,543,178.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17,223,277.50</b>	<b>7,123,199.00</b>
210401	Бичиг хэрэг	1,111,350.00	1,000,100.00
210402	Тээвэр, шатахуун	10,785,000.00	2,947,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,459,775.50	803,594.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	74,000.00	70,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,793,152.00	2,301,405.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,792,100.00</b>	<b>19,287,700.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	240,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	880,000.00	203,800.00
210604	Урсгал засвар	9,912,100.00	18,843,900.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>588,000.00</b>	<b>768,000.00</b>
210702	Дотоод албан томиллолт	588,000.00	768,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,200,000.00</b>	<b>3,670,500.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,200,000.00	481,000.00
210807	Газрын төлбөр	00.00	3,189,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>129,599,500.00</b>	<b>71,581,400.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	129,599,500.00	71,581,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>69,457,600.30</b>	<b>22,620,349.27</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>50,673,600.00</b>	<b>16,439,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	50,673,600.00	15,939,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	500,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>18,784,000.30</b>	<b>6,181,349.27</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>14,380,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>14,380,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>14,380,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>14,380,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	14,380,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>01.00</b>	<b>-14,380,000.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>01.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>01.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>01.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>01.00</b>	<b>00.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

	Үзүүлэлт	Тайлант оны	Биелэлт
--	----------	-------------	---------

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	491,383,600.00	480,498,050.73	10,885,549.27	97.8
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	491,383,600.00	480,498,050.73	10,885,549.27	97.8
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	474,944,600.00	464,059,050.73	10,885,549.27	97.7
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	236,000,000.00	235,988,351.04	11,648.96	100.0
210101	Үндсэн цалин	236,000,000.00	235,988,351.04	11,648.96	100.0
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	31,860,000.00	30,378,762.32	1,481,237.68	95.4
210201	Тэтгэврийн даатгал	22,420,000.00	21,318,900.00	1,101,100.00	95.1
210202	Тэтгэмжийн даатгал	2,360,000.00	2,327,562.32	32,437.68	98.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,888,000.00	1,795,300.00	92,700.00	95.1
210204	Ажилгүйдлийн даатгал	472,000.00	448,800.00	23,200.00	95.1
210205	Эрүүл мэндийн даатгал	4,720,000.00	4,488,200.00	231,800.00	95.1
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	144,600,000.00	140,945,138.37	3,654,861.63	97.5
210301	Гэрэл, цахилгаан	3,600,000.00	3,401,960.37	198,039.63	94.5
210302	Түлш, халаалт	135,000,000.00	135,000,000.00	00.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	6,000,000.00	2,543,178.00	3,456,822.00	42.4
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,604,900.00	7,123,199.00	481,701.00	93.7
210401	Бичиг хэрэг	1,010,000.00	1,000,100.00	9,900.00	99.0
210402	Тээвэр, шатахуун	2,888,000.00	2,947,600.00	-59,600.00	102.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	895,000.00	803,594.00	91,406.00	89.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	510,300.00	70,500.00	439,800.00	13.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,301,600.00	2,301,405.00	195.00	100.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	19,078,700.00	19,047,700.00	31,000.00	99.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	204,200.00	203,800.00	400.00	99.8
210604	Урсгал засвар	18,874,500.00	18,843,900.00	30,600.00	99.8
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	901,000.00	768,000.00	133,000.00	85.2
210702	Дотоод албан томилолт	901,000.00	768,000.00	133,000.00	85.2
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,233,400.00	5,170,500.00	62,900.00	98.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000,000.00	1,981,000.00	19,000.00	99.1
210807	Газрын төлбөр	3,233,400.00	3,189,500.00	43,900.00	98.6
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	29666600.00	24637400.00	5,029,200.00	83.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,666,600.00	24,637,400.00	5,029,200.00	83.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	16439000.00	16439000.00	00.00	100.0
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	16,439,000.00	16,439,000.00	00.00	100.0

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,939,000.00	15,939,000.00	00.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	00.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	491,383,600.00	480,498,050.73	10,885,549.27	97.8
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	322,909,100.00	320,413,212.36	2,495,887.64	99.2
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	322,909,100.00	320,413,212.36	2,495,887.64	99.2
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	163,474,500.00	159,789,038.37	3,685,461.63	97.7
132001	Орон нутгийн төсвөөс	163,474,500.00	159,789,038.37	3,685,461.63	97.7
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	5,000,000.00	295,800.00	4,704,200.00	05.9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	295,800.00	4,704,200.00	05.9
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	23.00	23.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00	00.00	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>60,064,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>60,064,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	60,064,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	13,120,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,120,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	46944000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,944,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	60,064,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	60,064,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	60,064,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Биеийн тамир, спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар

болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Биеийн тамир, спортын газар нь биеийн тамир, спортыг хөгжүүлэн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа явуулдаг Биеийн тамир спортын Улсын Хорооны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд: Засгийн Газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"-ыг хэрэгжүүлэх, "Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн Тэтгэврийн даатгал-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, Тэтгэврийн даатгал-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, Шимтгэлийн дүн-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.7" гэснийг "11.7" гэж, Шимтгэлийн дүн-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.5" гэснийг "11.5" гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн "12.5 хувиас" гэснийг "11.5 хувиас" гэж тус тус өөрчилсүгэй" гэж заасныг хэрэгжүүлж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 818.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 16.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 13.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Биеийн тамир, спортын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 124.6 сая төгрөгөөр буюу 4.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн дансны үзүүлэлттэй холбоотой байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	13.3	0.6	-12.7
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	33.1	46.6	13.5
Үндсэн хөрөнгө	4,059.4	3,934.0	-125.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,105.8</b>	<b>3,981.2</b>	<b>-124.6</b>
Өр төлбөр			0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,105.8	3,981.2	-124.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>4,105.8</b>	<b>3,981.2</b>	<b>-124.6</b>

Тайлант онд мөнгөн хөрөнгө, өр төлбөр данс үлдэгдэлгүй байна.

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 13.5 сая төгрөгөөр өсөж 46.6 сая төгрөг болсон нь тусгай зориулалтын материал 7.5 сая төгрөгөөр, барилгын засварын материал 3.2 сая төгрөгөөр, бусад хангамжийн материал 2.7 сая төгрөгөөр тус тус өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,934.0 сая төгрөг болж 125.4 сая төгрөгөөр өссөн нь үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийг үнэлж орлого болгосонтой холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3981.2 сая төгрөг болж өмнөх оноос 124.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 266.9 сая төгрөгөөр буюу 30.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үзүүлэлт нь тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 322.9 сая төгрөгөөр өссөн, Орон нутгийн төсвөөс санхүүжих 334.2 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлого 163.6 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 95.9 сая төгрөгөөр буюу 11.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл өсөн, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал буурсан, эд хогшил, урсгал засварын зардал буурсан байна. Энэ нь нийгмийн даатгалын тухай хуульд орсон өөрчлөлт, төсвийн хэмнэлтийн бодлогын хэрэгжилттэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүн рүү хаасан 0.9 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга, дахин үнэлгээний нөөцийн бууралт, тайлант үеийн үр дүн 124.6 сая төгрөгөөр нөлөөлсөн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Биеийн тамир, спортын газрын 2021 оны төсвийн төслийг 444.6 сая төгрөгөөр тооцон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Биеийн тамир, спортын газар нь 2021 онд 491.4 сая төгрөг батлагдсанаас 486.7 сая төгрөгийн санхүүжилт авч, 480.5 сая төгрөг зарцуулж 10.9 сая төгрөг хэмнэж улсын төсөвт 6.2 сая төгрөг татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргаас 37.4 сая төгрөг, Биеийн тамир спортын улсын хорооноос 9.5 сая төгрөг, сангийн яамнаас өмнөх оны татан төвлөрүүлсэн санхүүжилтийн авлага 13.1 сая төгрөгийн нийт 60.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч 37.4 сая төгрөгийг тив дэлхий, олон улс, улсын чанартай тэмцээнд амжилт гаргасан багш, дасгалжуулагч, тамирчинд, 8.7 сая төгрөгийг нийтийн биеийн тамир спортын арга хэмжээнд, Мэдээллийн цахим сан бүрдүүлэлтийн техник хэрэгслийн зардалд 13.1 сая төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд:

- Корона вирус -2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан.
- Улсын болон орон нутгийн онцгой комиссын шийдвэрээр хөл хорио тогтоосны улмаас биеийн тамирын заалаар үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ хязгаарлагдмал байсан.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан тул санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал нь Засгийн Газраас баримталсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг хэрэгжүүлж 6.2 сая төгрөгийн хэмнэлт гаргасан явдал байна. Үүнд: материаллаг хэмжээтэй ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 1.4 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3.6 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 5.0 сая төгрөгийн зардлыг тус тус хэмнэсэн байна.

Өөрийн орлогын 5.0 сая төгрөгийн төлөвлөгөөний биелэлт 0.3 сая төгрөгөөр биелсэн нь Цар тахалтай тэмцэхтэй холбоотой хөл хорио тогтоосонтой холбоотой байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээлбэл зохих 995.3 сая төгрөгийн 70 мэдээллээс 995.3 сая төгрөгийн 70 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлтэй нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн байдлыг анхаарч үзэх нь зүйтэй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 0.6 сая төгрөгийн алдаа илэрснээс, 0.6 сая төгрөгийн алдааг залруулсан болно.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 0.6 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдаа илэрснийг аудитын хугацаанд залруулсан болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Биеийн тамир, спортын газар	2	0.6	2	0.6						